

ТӨВ АЗИЙН ХҮРЛИЙН ХОЖУУ ҮЕИЙН ОВОГ АЙМГУУДЫН СОЁЛЫН ХАРИЛЦАА БА ТЭЭГИЙН ХАДНЫ ЗУРАГ

З.БАТСАЙХАН¹, У.ЭРДЭНЭБАТ², Б.ОЮУНТУЯА³, Ч.АМАРБИЛИГ⁴

¹ МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим, batsaikhanzagd@gmail.com

² МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим, u_erdenebat@yahoo.com

³ МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим, batsaikhanzagd@gmail.com

⁴ БНХАУ-ын Жилиний Их Сургууль, dd_amaraa@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГС: Монголын археологи, хожуу хүрлийн үе, хадны зураг

ТОВЧ АГУУЛГА: ШУТС-гийн санхүүжилтээр МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхим, Биологийн тэнхимээс 2014-2016 онд хамтран хэрэгжүүлсэн "Монголын эртний нүүдэлчдийн угсаа гарвалын залгамж холбоо" (Археологи, молекул-генетикийн судалгаа) сэдэвт ажлын (Дугаар: SSA_033/2014) хүрээнд Баянхонгор аймгийн нутагт хийсэн эртний судлалын хайгуул шинжилгээний үр дүнгээс энэхүү өгүүлэлд нийтэлжээ. Тээгийн хадны зургууд ялангуяа, Тахилга уулын зургууд археологийн үечлэлээр хожуу хүрлийн эхнээс төмрийн түрүү үе хүртэлх цаг хугацааг хамарна. Хиргисүүрийн талбайд орших хадны зургийг сонгон судалсан анхны туршиц ажлаар хиргисүүрийн соёлыг тээгчдийн нийгэм, соёл, аж ахуйд гарсан өөрчлөлт, шүтлэг бишрэлийн тухай ойлголт төсөөлөл зэрэг олон талт асуудлыг эх сурвалж болгон судлах өргөн боломж байгаа нь харагдаж байна.

“Монголын эртний нүүдэлчдийн угсаа гарвалын залгамж холбоо” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн нутагт хадны зураг, хиргисүүрийн хайгуул судалгаа зохион явуулсан юм. Учир нь хүрлийн хожуу үеэс өргөн уудам газар нутгийг хамарсан соёлын хэд хэдэн нийтлэг хэлбэршин тогтсон бөгөөд үүнээс хамгийн тод томруун өвөрмөц нийлмэл бүтэц зохион байгуулалттай цогц дурсгал бол хиргисүүр, буган хөшөөний соёл болно. Уг соёлын хүрээнд буган чулуун хөшөө, дугуй ба дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, хүрээгүй дугуй ба дөрвөлжин хэлбэртэй булшнууд болон олон дагуул бүхий асар том цогцолбор байгууламжууд багтаж байгаа юм. Түүнчлэн, энэхүү соёлын хүрээнд оруулан хэлэлцвэл зохих дурсгалын нэг бол хадны сүг зураг болно. Гэхдээ, юуны өмнө чухам ямар дүрслэл, сэдэв болон дүрслэлийн аргаар хийсэн зургууд уг соёлд хамаарахыг тогтоох нь чухал байлаа. Үүний тулд хадны

зураг, хиргисүүр хоёр нэг талбайд зэрэгцэн оршиж буй газрыг олж сонгон ажиглалт судалгаа хийхэд зурагтай чулууг хиргисүүрийн дараасанд ашигласан тохиолдлыг илрүүлсэн юм.

Судалгаанд орсон Холбоо тээг хэмээх газар нь Хангайн нуруу, говийн завсарт байх хадан гарц бүхий тэгш өндөрлөгүүдийн баруун зах бөгөөд Байдрагийн голоос зүүн тийш 40 гаруй км зайд оршино. Тээг, Тэвш, Хүрэм гэх зэргээр нэрлэх эдгээр тэгш өндөрлөгүүд нь Их, Бага Богд болон Арц Богдын нурууны араар Хангайн нурууны өвөр этгээдээр Байдрагийн голын зүүн талаас эхлэн Өвөрхангай аймгийн Богд сумын зүүн талын Тэвш уул хүртэл үргэлжлэх бөгөөд Хангайн нуруунаас эх аван урсах Байдраг, Түйн гол болон Таацын голын завсар хооронд оршино. Эдгээр тээгүүдээр гол төлөв хиргисүүр болон цөөн тооны бусад хэв шинжийн олон тооны дурсгалууд байдаг боловч зөвхөн Богд сумын

Тэвш уулын дурсгалууд бага хэмжээгээр судалгааны хүрээнд оржээ.

Холбоо тээгийн урд энгэрийн хадан гарцууд дээр 60 орчим хавтгайд 180 гаруй зураг байх ба хадан гарцуудын хооронд дугуй ба дөрвөлжин хүрээтэй, хүрээгүй дугуй, дөрвөн талдаа хөшөөтэй дөрвөлжин болон цагариг хэлбэртэй 42 хиргисүүр байна. Тухайн талбайд өөр цаг үеийн бусад хэв шинжийн булш байхгүй байгаа нь ажиглалт судалгаа хийхэд маш тохиромжтой газар болсон юм. Талбайд бүртгэн тэмдэглэсэн 42 хиргисүүрийн 8 хиргисүүрийг байгуулахад дээрх зурагтай хаднаас авч ашигласан байлаа. Зурагтай чулууг хиргисүүрийн хүрээ болон буланд тавьсан байна. Хиргисүүрт зурагтай хад чулууг ашиглахдаа зураг дүрстэй талыг дээш харуулан тавьсан байх боловч толгой тал нь доош харж хөрсөнд дарагдсан тохиолдол бас байлаа. Гэвч хиргисүүрийн хүрээ чулуун дээр хожим сийлсэн боловч уу гэмээр ганц нэг тохиолдол байгаа ба I-54, 57 хэмээн дугаарласан зургийг булшны хашлаганы булангийн өндөр чулууны дээд өнцөгт сийлсэн байна. Булшны чулуун дээрх зураг болон хадан дээрх зургуудад амьтдыг ижил арга хэлбэрээр дүрсэлсэн байгаа ба сэдэв дүрслэлийн нэгдэл нь нэгэн үеийн зураг болохыг харуулна.

Судалгаанд хамрагдсан хадны зураг бүхий дараагийн талбай бол Түйн голын зүүн эргээс эхлэн зүүн зүг 20 км орчим зайтай Тэвшийн хүрэм хэмээх тээгийн шувтаргад байх Тахилга уул болно. Уулын хормойгоос үргэлжлэх багавтар өвдөг болон түүний баруун талд орших бяцхан толгойн 120 орчим хавтгайд 530 гаруй зураг байхаас гадна өвөрт нь 4 дөрвөлжин булш, 2 хиргисүүр байх ба 2 дөрвөлжин булшны хашлаганд зурагтай хадыг ашиглажээ. Үүнээс гадна Тахилга уулын баруун зүүн талаар дугуй ба дөрвөлжин хүрээтэй 20 хиргисүүр бий. Гэхдээ дээр өгүүлсэн газар нутаг нь хиргисүүрийн өргөн тархалтын бүс нутаг бөгөөд харин дөрвөлжин булш болон шоргоолжин булш нь тархалтынхаа төвийн зах хязгаарт ховор байдаг нь ажиглагдлаа.

Асуудал ба судалгааны арга зүй

Хүрлийн хожуу үед Төв Ази, Өмнөд Сибирьт хадны зураг урлалын онцгой дэг маяг дэлгэрсэн байна. Тухайлбал, дүрсийг геометрчлэх, тойм загвараар илэрхийлэхийн хамт тодорхой хэв шинжит дүрүүд, баатрууд гарсан ажээ. Үүний зэрэгцээ Монгол, Тува, Алтай, Казахстан болон Хакас-Минусын хотгорын хадны зурагт орон нутгийн ялгаа, уран сайхны олон янзын уламжлал дүрслэлийн өөрийн гэх арга илэрч байдаг тухай судлаачид дурджээ. Гэхдээ дээрх газар нутагт нэгэн ижил хэлбэр маягаар дүрсэлсэн олон тооны хадны зураг бий. Жишээлбэл: тэрэг, тодорхой аргаар дүрсэлсэн морь, буга, янгир болон хүний дүрсийг дурдаж болох юм. Түүх соёлын нэг бүсэд ийнхүү ижил төстэй тал байх нь зүй ёсны үзэгдэл мэт боловч үүний зэрэгцээ зөвхөн тухайн орон нутгийн хүрээнд дэлгэрсэн онцгой дүр дүрслэлийг илрүүлэх нь бидний зорилго болно.

Урлаг бол хүмүүний соёлын нарийн төвөгтэй үзэгдэл бөгөөд олон талын хүчин зүйлийн нөлөөгөөр хэлбэршин бий болдог. Ийм учраас хангай, говийн завсарт орших хүрлийн хожуу үеийн хадны урлагийг судлахад цогц арга замаар хандах ёстой.

Холбоо тээг, Тахилга уулын хадны зургууд нь НТӨ II мянганы эцэст нийгэм, соёлд гарсан үзэл санааны өөрчлөлтийг тусгаж байгаа түүхэн чухал сурвалж болно. Ялангуяа, дээрх хадны зургууд археологийн ландшафтын бүрэлдэхүүн хэсэг буюу хиргисүүртэй нэг талбайд зэрэгцэн оршиж буй нь тэдгээр зургийн харьцангуй он цагийг тогтоох нэгэн сэжүүр болохоос гадна хиргисүүр болон тухайн хадны зураг хоёрын хооронд холбоо харилцаа байгаа эсэх нь судалгааны сонирхолтой сэдэв мөн боловч түвэгтэй ажил юм.

Монголын хүрлийн хожуу үеийн нэгэн өвөрмөц дурсгал бол Монгол Алтайгаас Сүхбаатар аймгийн баруун тал хүртэлх газар нутагт өргөн тархсан хиргисүүр, буган хөшөөний соёл болно. Эдгээр дурсгалууд нь дугуй ба дөрвөлжин хүрээтэй мөн хүрээгүй дугуй, дөрвөлжин хэлбэртэй байхаас гадна

зарим нь олон дагуул байгууламжтай гэх мэт нарийн нийлмэл бүтэц, зохион байгуулалттай байна. Монголын хиргисүүр нь бүтэц зохион байгуулалтын зарим нэг шинж тэмдэг, хүрээ гэх мэтээрээ Тувагийн Мөнгөн тайгын дурсгалуудтай төстэй талууд байгаа ба ялангуяа, Баруун Монголын хиргисүүрт илүү тод илэрч байдаг. Гэвч Монголын хиргисүүр нь хөгжлийн явцад өөр орчин нөхцөлд эрс ялгарахуйц бие даасан соёл болон хөгжсөн байна. Үүний тод томруун жишээ бол уг соёлын салшгүй хэсэг буган чулуун хөшөө мөн. Булшинд эд өлгө дагуулан тавьдаггүй оршуулгын зан үйлийн өвөрмөц онцлогоос үүдэн хиргисүүрийн малталт судалгаагаар эд өлгийн зүйл тоотойхон олдсон боловч буган хөшөөнд нум, хутга, матга, байлдааны сүх, ээмэг, бүс гэх мэт зэр зэвсэг, гоёл чимэглэл дүрсэлсэн байх нь элбэг. Гэсэн хэдий ч хиргисүүр, буган хөшөөний соёлыг тээгчдийн оюун санааны амьдралын олон талыг судлах шинэ хэрэглэгдэхүүн бий болгох нь судалгааны гол зорилго юм.

Эртний дүрслэх урлагийн бүх бүтээлүүд тодорхой зүйлийн дүрслэл болохын хамт тэдгээртэй холбоотой үзэл санааны цогц илэрхийлэл болж байдаг. Иймээс хадны зургаас илүү бүрэн дүүрэн мэдээлэл авахын тулд олон цогц аргыг судалгаанд хэрэглэх шаардлагатай болдог. Эдүгээ шинжлэх ухааны шаардлагад нийцсэн олон талт задлан шинжилгээний синтезийг хэрэглэж байгаа ба янз бүрийн арга зүйг нэгтгэх замаар судалгааны нэгдмэл бааз суурь бий болгох хандлагыг эрж хайж байна. Энэ шаардлагад нийцсэн шинж тэмдгийн буюу семиотикийн аргыг хадны зургийн судалгаанд өргөн хэрэглэж байгаа юм. Гэхдээ хөгжлийн тодорхой шатанд байгаа аль нэг нийгмийн хэрэгцээнд нийцэж байсан эртний дүрслэлийг зураг, тэмдгийн систем гэж ойлгон хүлээн авах хэрэгтэй юм. Шинж тэмдгийн аргаар тайлбарын утгын бүтцийг судлах арга гурван үе шатыг дамжина. Эхний шатанд дүрслэлийн объектыг тодорхойлох, дараагийн шатанд дүрслэлийн янз бүрийн хувилбаруудыг ялган

схем гаргах, эцэст нь дүрслэлийн агуулгын талаар дүгнэлт хийнэ.

Ойлголтын үндсэн элементийн дотор дүрслэлийн уламжлал ба хэв маяг гэдэг тусдаа ойлголт бий бөгөөд түүх, соёлын тодорхой хүрээнд гарсан бүх үйл явцыг хамарч байдаг. Дүрслэлийн уламжлал нь уран сайхны аргын онцлогоор илрэх дүрслэлийн хэв маягтай харьцуулахад илүү гүн гүнзгий үндэстэй байдаг ажээ. Иймээс дүрслэлийн нэг уламжлалын хүрээнд хэв маягийн хэд хэдэн хувилбар байна. Урлаг судлалд хэв маягийн анализын үндсэн дээр тулгуурлан дүр, дүрслэлийн ба энгийн хэв маягийн аргыг боловсруулсан бөгөөд археологийн, урлагийн дурсгалуудыг тодорхойлоход өргөн хэрэглэж байна. Хадны зургийн нэг уламжлалын хүрээнд тодорхой зураг дүрслэлүүдэд илэрч байдаг өвөрмөц тал нь хувь хүний дүрслэх онцлогтой холбоотой.

Хадны зургийн судалгаанд археологийн хэрэглэгдэхүүнийг задлан шинжилж, харьцуулж, хэв шинжийн ангилал гаргахад түүхэн харьцуулалтын арга чухал байр суурь эзэлнэ. Энэ аргын хүрээнд угсаатны зүйн хэрэглэгдэхүүн дээр түшиглэсэн угсаатны зүйн зэрэгцүүллийн аргаар зарим дүр дүрслэл, сэдвийг тайлбарлах боломж гардаг. Гэхдээ угсаатны зүйн харьцуулалтад авсан ижил төстэй жишээ нь түүхэн бодит байдалтай уялдах ёстой.

Хадны зургийн он цагийг булшны чулуун дээрх зураг, амьтны загварт хэв маягаар хийсэн хүрэл хутга, матга болон хүрэл гоёл чимэглэл дээрх амьтдын дүрс, ваарны чимэглэл зураг зэрэгтэй харьцуулан тогтоох аргыг хэрэглэх нь илүү үр дүнтэй байх ажээ.

Хадны зургийн дүрслэлийн уламжлал ба Монголын хадны зургийн судалгаа

Монголын хадны зурагт тус бүс нутгийн хүрээнд окунев, сеймо-турбин, варчин болон геометрийн дүрслэлийн уламжлал тод харагдаж байдаг бөгөөд сүүлийн гурав нь Баруун Монгол төдийгүй Говь-Алтайн нуруу, Хангайн нуруу, говь, тал хээрийн бүсийн

хадны зурагт ямар нэгэн байдлаар адил илэрч байна.

Варчины дүрслэлийн арга. Энэ арга нь судалгааны нэгэн идэвхтэй чиглэл болон хөгжиж байгаа бөгөөд анх судлаач Б.Н.Пяткин томьёолон тавьжээ (Пяткин, 1977). Тэрээр эдгээр хадны зургийн соёл, он цагийн ялгаа чухал болохыг онцлон тэмдэглэсэн байна. Хүрлийн үеийн дүрслэх урлагийн уламжлалд гарсан уг өөрчлөлт нь өмнөх үеийн дүр, дүрслэлээс үндсээрээ ялгаатай гэдэг дээр судлаачид санал нэг байгаа юм. Баруун Хойд Алтай, Соёны дүрслэх урлагт эрс өөрчлөлт гарч зарчмын хувьд өөр шинэ сэдэв дүр төрх бий болсон бөгөөд хандгай, үхэр мэт амьтдын дүр морь болон морьтой холбоотой сэдэвт шахагдан зайгаа тавьж, адуу нь дүрслэлийн гол бэлгэдэл болжээ. Үүнээс гадна янгир, аргаль, буга, бух түүнчлэн, тэрэг, нумаар зэвсэглэсэн хүнийг дүрслэх болсон юм (Пяткин, Миклашевич 1987; Миклашевич, 1995; Савинов, 1993). Дүрслэлийн хэв маяг үндсээрээ хувьсан өөрчлөгдсөн бөгөөд зургийн геометрийн дүрслэлийн арга Алтай, Соёны хүрлийн хожуу үеийн дүр, дүрслэлд зонхилох болсныг судлаачид онцлон тэмдэглэжээ. Хэдийгээр энэ чиг хандлага янз бүрээр илэрдэг боловч тэдгээрийг зарчмын ижил төстэй тал нь нэгтгэж байдаг гэжээ. Советово, Миклашевич нар нэгэн хэв маягийн хүрэн дэх хувилбарууд нь он цагийн хамааралгүй, харин угсаа соёлын ялгаатай хэмээн үзсэн байна.

Дээрх шинж төрхийн чиг хандлага зөвхөн Алтай, Соёны баруун хойд бүс нутгийн тодорхойлогч төрх биш бөгөөд дээрх дүр, дүрслэлтэй төстэй зохиомж Төв ба Баруун Хойд Ази, Дорнод Казахстан, Уулын Алтайн хүрлийн хожуу болон төгсгөлийн шатны соёлын харилцан нөлөөллийн бүсэд бий болжээ.

Судлаач Леонтьев Енисей мөрний дунд этгээдийн хэрэглэгдхүүн дээр тухайн газрын нэрээр варчинский буюу варчины гэж нэрлэх болсон ба зарим нэг үндэслэлээр карасукийн он цагт холбогдож магадгүй гэж үзсэн ажээ (Леонтьев, 1980). Мөн тэрээр варчины

дүрслэлийн анхны ангиллыг дараах байдлаар хийжээ. Нэгдүгээрт: зураасан сүүдэр зураг, хоёрдугаарт: зураасан тэг зураг, гуравдугаарт: болзолт бодит зураг гэх мэтээр ангилсан байна. Түүний ангилал нэгдмэл үндэслэлд тулгуурлаагүй боловч үндсэн чиг хандлагыг зөв тавьсан байдаг (Ковтун, 2001). Ковтун уг ангиллын зарим нэрийг засаж, сүүдэр зураг, зураасан зураг гэж өөрчлөхийн хамт бодит болзолт зургийг сүүдэр зургийн ангилалд багтаасан байна.

Геометрийн дүрслэлийн уламжлал. Энэ нь амьтдын биеийг гол төлөв тэгш өнцөгт дөрвөлжингөөр дүрслэх уламжлал болох бөгөөд Алтай, Соёны хөрш зэргэлдээх соёлуудад янз бүрийн хувилбараар илэрдэг ажээ. Зарим судлаачдын үзэхээр уг арга карасукийн соёлоос гаралтай бололтой (Пяткин, Миклашевич 1987).

Монголын хүрлийн хожуу үеийн хадны зурагт геометрийн дүрслэлийн уламжлал тун бага илэрч байгаа боловч сүүдэр зургийн дүрслэл, зураасан дүрслэл өргөн дэлгэрсэн том бүс нутаг болж байна. Варчины дүрслэлийн уламжлал нь зөвхөн Өмнөд Сибирь, Монгол Алтай төдийгүй Хангайн нуруу, говь, тал хээрийн хүрлийн хожуу үеийн хадны зураг урлалын гол арга болж өргөн дэлгэрсэн байна.

Сеймо-турбины дүрслэлийн уламжлал. Өмнөд Сибирь болон Казахстаны хадны зургийн судалгааны нэг чухал ололт бол дүрслэлийн энэхүү уламжлалыг бусад зургаас ялган тархалтын хүрээг тогтоож өгсөнд оршино. Уламжлалын онцлог нь гол төлөв том толгойтой, бүдүүн хүзүүтэй, бахим биетэй, сүүлээ өргөн зогсож байгаа болон уургын морь мэт сууж байгаа нэг эсвэл сүрэг адууны зураг болно (Савинов, 2007). Сеймын дүрслэлийн уламжлалаар зурсан хадны зургийн ихэнх хэсэг нь Төв болон Дорнод Казахстан буюу Эрчис мөрний баруун этгээдээс олдсон (Самашев, 1992; Новоженев, 2002) бөгөөд тэндээс Монгол Алтайд тархжээ (Новгородова, 1984; Кубарев 2007). Харин Енисейн дунд бие, Тувад байдаггүй ажээ. Харьцуулсан хэв маягийн судалгаанаас үзвэл

Төв Азийн умард болон Казахстаны зургууд он цагийн өргөн хүрээг хамрах бөгөөд дүрслэлийн энэ уламжлалыг тээгчид анхны тархалтын төвтэй холбоотой байж болно гэжээ. Түүнчлэн, сеймын уламжлалд багтах зургийн он цагийн асуудлаар судлаачдын дунд янз бүрийн байр суурь байгаа ба Пяткин нар сеймо-турбины үзэгдлийн эхэн үед холбогдох санал гаргасан боловч зарим судлаачид эргэлзэж буйгаа илэрхийлсэн байна. Самашев хүрлийн хожуу үеийн төгсгөл, сакийн өмнөх болон түрүү үед холбогдоно гэж үзсэн (Самашев, 1992) бол Новоженев Байконурын дээрх хэв маягийн олон тооны зургийн он цагийг хүрэл, хүрлийн хожуу үе ба түрүү нүүдэлчдийн үеэр тогтоосон байна (Новоженев, 1993). Сеймо-турбины соёл болон он цагт холбогдох хадны зургуудтай төстэй морины дүрстэй хүрэл, чулуун эдлэлүүд цөөнгүй олдсоор байгаа нь дээрх зургуудын ихэнх хэсгийн цаг үеийг тогтоох нэг боломж байж болох юм гэж үздэг байна. Харин огцом зогсох мэт хөдөлгөөнтэй дүрсэлсэн морьд сакийн үед холбогдох нь эргэлзээгүй (Савинов, 2007).

Сеймо-турбины соёлын үзэгдэл нь Монголд Мөнххайрханы хэв шинжийн дурсгалд илэрдэг бөгөөд Ховд, Хөвсгөл аймгийн нутагт цөөн тооны булш малтжээ.

Ийнхүү хөрш орны хадны зургийн судалгаа нь газар бүрийн хадны зургийн дүр, дүрслэлийн уламжлал, онцлог ба ялгааг нээн илрүүлж зургийн он цагийг нэг үеийн дотор нарийвчлан гаргаж ямар соёлын хүрээнд багтах, үүсэл гарвалын асуудлыг судлахад голлон анхаарч байгаа нь харагдана.

Монгол Алтай, Говь-Алтайн нуруу, Хангайн нуруу болон говийн бүсэд тархсан хүрлийн үеийн хэдэн арван мянган хадны зураг байгаа ба тэдгээрийн багахан хэсэг нь судалгааны хүрээнд орсон байна. Монголын хадны зургийн судалгааг товчоор тодорхойлоход эхлээд зургийг бүтээсэн аргыг бичээд хадны зурагт дүрсэлсэн амьтдыг нэг бүрчлэн тодорхойлохын зэрэгцээ тухайн газарт зурсан амьтдын эзлэх хувийг гаргаж ангиллын энгийн зарчмаар амьтдыг төрөл

зүйлээр нь бүлэг болгон хувааж үзээд эцэст нь зэргэлдээх газар орны зурагтай харьцуулан он цагийг ойролцоогоор тогтоосон байдаг. Гэтэл Монголын хүрлийн түрүү үе, хөгжингүй үе болон хожуу үеийн хадны зургийн нарийвчилсан он цаг, дүр дүрслэл, сэдэв, өмнөх ба нэг цаг үеийн соёлуудын дүрслэлийн уламжлалтай хэрхэн холбогдож байгаа эсэх Монголын хадны зурагт дүрслэлийн бие даасан уламжлал байна уу гэх мэт чухал асуудал байгаа юм.

Холбоо тээг ба Тахилга уулын хадны зургийн сэдэв дүрслэл ба он цаг

Холбоо тээг, Тахилга уулын хадны зургууд хүрлийн хожуу үеийн янз бүрийн цаг хугацаанд бүтээгдсэн бөгөөд бусад дурсгалуудын хамт нийгэм, үзэл суртал болон соёлын хүрээнд гарсан өөрчлөлт хадны зургийн хувьсал хөгжилд тусаж байгаа түүхэн чухал сурвалж болно. Хадны зургууд гол төлөв эдийн засаг, аж ахуйн ач холбогдолтой газруудад хамгийн элбэг байх ажээ. Үүний зэрэгцээ гол зам харгуй, байнгын оршин суух өвөлжөө, зуслан, үе үе цугларах тахил тайлгын зан үйл явуулдаг газарт харьцангуй түгээмэл тохиолдохоос гадна эртний оршуулгын газар ялангуяа, хиргисүүртэй газарт мөн нэгэн адил байна. Их хэмжээний хадны зурагтай газарт түүхэн олон үеийн булш байгаагаас үзэхэд тухайн нутагт угсаа гарвалын хувьд ойролцоо, сэтгэл зүйн нийтлэг хэв шинжтэй бүлгүүд оршин сууж дүр дүрслэл, сэдвийг уламжлуулан залгамжлуулж байжээ.

Баянхонгорын тээгүүдийн хүрлийн хожуу үеийн дүрслэлийн нэгдмэл уламжлалын хүрээнд зурсан хадны зургуудын маяг, загварын хувилбаруудыг он цагийн ялгаатай хэд хэдэн бүлэгт хуваан үзэж болохоор байна.

Хүрлийн хожуу үед илүү өргөн дэлгэрсэн гол дөрвөн бүлэг сэдэв байдаг гэж судлаачид үздэг. Үүнд: хүн ба амьтдын дүрс бүхий сэдэвт зураг, элдэв дүрс тэмдэг байхаас гадна тэрэг болон дугуйн дүрс нэг онцгой бүлэг болж орно. Хүрлийн хожуу үеийн бүх хадны зургийн тал хувийг туурайтан амьтдын зураг

эзлэх ба ялангуяа, адууны зураг түээмэл байна. Адууг сүргээр нь, ганц нэгээр нь мөн өөд өөдөөсөө харан зогсож байгаагаар зурсан байхын хамт тэргэнд хөллөсөн, унасан байдлаар дүрсэлсэн байх нь элбэг. Хүрлийн хожуу үед адууны дүрс зонхилох болсон нь морийг унаж эдлэх болсонтой холбоотой түүхэн нөхцөлийн илрэлийг тусгаж байх ажээ. Харин үхэр, нохой болон бусад араатан амьтдын зураг харьцангуй цөөн тохиолдоно.

Дүрслэлийн сэдвийг задлан шинжилж үзэхэд хүрлийн хожуу үеийн хадны зурагт өмнөх үеийн дүрслэлийн уран сайхны уламжлал заримдаг хэлбэрээр хадгалагдан үлдсэнийг ажиглаж болно. Тухайлбал, зарим бэлгэдлийн дүрс, амьтдын туурай болон үржлийн эрхтэний үзүүрийг бөмбөлөг хэлбэртэй зурах, үхэр, буга зэрэг амьтныг өмнөх үеийн дүрслэлийн тэг, маяг загвараар зурсан зэргийг дурдаж болно. Үүний зэрэгцээ дугуйт тэрэг, морьтой холбоотой дүрслэлийн шинэ хэв шинжийн дүр дүрслэл гарсан гэж үздэг байна.

Тува, Минусын хотгор болон Дорнод Казахстаны хадны зургийн уламжлалын зэрэгцээ Төв Азийн хадны зургийн дүр дүрслэлтэй холбоотой мөөгөн малгайт, нум сумаар харваж буй хүн, дотроо олон цэгтэй тэгш өнцөг дөрвөлжин дүрс бий болжээ. Энэ тохиолдол нь хадны зургийн дүрслэлийн уг уламжлалыг тээгчид Төв Азиас Өмнөд Сибирьт шилжин очсонтой холбоотой (Ковалева, 2008).

Холбоо тээг ба Тахилга уулын 700 гаруй хадны зурагт хүн болон туурайтан амьтдын дүрс зонхилохоос гадна цөөн тооны махчин амьтад, тамга тэмдэг ба дөрвөлжин дүрс, хүн ба амьтад оролцсон сэдэвт зураг гэх мэт дөрвөн бүлэг байна. Дурдсан хоёр газар нь хоорондоо 100 км орчим зайтай орших бөгөөд яг ижил дүр дүрслэл цөөнгүй байхын зэрэгцээ ялгаатай өвөрмөц зураг байгааг анзаарч болно. Хадны зургийн ихэнх хэсэг нь хүрлийн хожуу үеийн Төв Ази болон Өмнөд Сибирьт өргөн дэлгэрсэн варчины болон сеймын дүрслэлийн уламжлалаар бүтээсэн орон нутгийн онцлогтой тухайн үеийн сэдэв, хэв

маягийг бүрэн илэрхийлэх зургууд байна. Тээгийн хадны зургийн дүр дүрслэл болон урын сан нэн баялаг болох нь ажиглагдлаа (Таб. 1).

Холбоо тээгт 180 гаруй сэдэв, дүр дүрслэлийн хувьд цөөвтөр зураг байгаа боловч хиргисүүрийн оршуулгын талбайд нэг дор хамт оршиж байгаа нь маш чухал үзүүлэлт болох бөгөөд хиргисүүрийн соёлыг тээгчдийн оюуны соёлын зарим талыг хангалттай төсөөлөх сурвалж гэж үзвэл зохино.

Зураасан дүрслэлийн бүлэгт: Дүрсийг танигдах төдий тоймлон зурсан олон зураг багтах бөгөөд хүрлийн хожуу үеийн ихэнх дурсгалд бий. Уг хэв маягаар дүрсэлсэн амьтад янз бүрийн сэдэв, зохиомж нь ан гөрөө, бүлэг амьтдын бөөгнөрөл дунд болон ганц нэгээр зурсан байна. Зураасан дүрслэлийн хэв маягаар амьтдыг зурахдаа гол төлөв шулуун, цөөн тохиолдолд муруй шугамуудыг холбон хийсэн байхаас гадна сүүдэр зургийн арга болон зураасан зургийн завсрын хэв маягаар зурсан хадны зургийн олон хувилбар байна (Таб. 1). Тээгийн зурагт амьтдын туурай, үржлийн эрхтэнг дугуй хэлбэртэй, биеийг урт мурилзсан болон шулуун зураасаар дүрслэх зэрэг уран сайхны илэрхийллийн хувийн онцлог, дэг маяг тод харагдаж байна. Дүрслэлийн энэ арга хүрлийн хожуу үеийн Минусын хотгорын зарим газрын зурагтай ижилсэж байгаа юм. Мөн нэг дүрсэнд дээрх хоёр аргыг хослуулан хийсэн байна.

Сүүдэр зургийн дүрслэлийн хэв маяг нь зураасан зурагтай нэг сэдвийн хүрээнд байх нь цөөнгүй ажиглагдана. Энэ тохиолдол тэдгээрийг нэгэн үеийн зураг гэдгийг харуулдаг. Дүрслэлийн энэ хэв маяг нь амьтдын бие галбирын онцлогийг харьцангуй бодит байдалд ойртуулсан байх ба хувь хүний дүрслэлийн олон янзын хэв маяг өмнөх үеийн уламжлал хүртэл илэрч байдаг. Сүүдэр зургийн хэв маяг хөгжлийн явцад хувьсан өөрчлөгдөж уран сайхны хэтрүүлгийн үндэс тавигдсан байна. Туурайтан амьтдын мундаа нүдэнд тусахуйц гурвалжин дүрстэй болж хөлийг хөдөлгөөнтэй байдлаар зурж аргаль, янгир, буга гэх мэт амьтдын эврийг үлэмж

сүрлэг байдлаар дүрслэх зэрэг Алтайн амьтны загварт урлагийн зарим элемент гарсан бөгөөд богино хугацаанд Төв Азийн урлагийн зонхилох хэв маяг болж зарим соёл тодруулбал, хиргисүүр, буган хөшөөний соёлын тодорхойлогч гол шинж тэмдэг болон төлөвшжээ.

Геометрийн дүрслэлийн уламжлалын хэв маягийг тодорхойлогч шинж тэмдэг нь амьтдын биеийг тэгш өнцөгт дөрвөлжингөөр дүрслэх арга бөгөөд энэ уламжлал тээг болон говийн хадны зурагт цөөвтөр байна. Уг аргаар гол төлөв туурайтан амьтдыг зурсан байх аж.

Сеймын дүрслэлийн уламжлалын хэв маягийн онцлог нь өмнө өгүүлсэнчлэн нэг ба сүрэг адууг гол төлөв босоо дэлтэй бүдүүн хүзүүтэй бахим биетэй дүрслэх арга бөгөөд Холбоо тээг, Тахилга уулын хадны зургийн ихэнх адууг дурдсан хэв маягаар зурсан байна (Зураг I-11, 18, 20, 27, II-19, 42, 53, 54, 61, 69, 72, 77, 93, 113). Гэхдээ морины туурайг дугуй дүрсээр зурах, дөрвөн хөлтэй давхиж байгаа мэт хөдөлгөөнтэй зурсан ялгаа харагдахаас гадна сүрэг адуу, буга, янгир, хүний дүрсийг нэг зохиомжид оруулан зурах болсон байна. Сеймын дүрслэлийн уламжлал Тээгийн хадны зурагт ийнхүү чухал байр суурь эзлэхийн хамт адууг нарийн урт хүзүүтэй зурах зэрэг дүрслэлийн хэв маяг хувьсан өөрлөгдсөн тал ажиглагдаж байна. Дээрх өөрчлөлт, сүрэг адууны зохиомжийн нэгдэлд орж буй бугыг Алтайн амьтны загварт урлагийн хэв маягаар зурсан зэрэг нь юуны өмнө он цагийн ялгааг харуулж байж болно.

Хадны зурагт амьтдыг таних гол шинж тэмдэг болох толгойн хэлбэр, эвэр, сүүл эцэст нь биеийн галбирыг аль нэг хэсэг, эсвэл бүхэлд нь танигдахаар дүрсэлсэн байна. Мөн нэг талбайд ижил төрлийн амьтад ялангуяа, гэршүүлсэн амьтдыг илт өөр өөрөөр зурсан байх нь цөөнгүй ажиглагдана (Зураг II-42, 69, 82, 85, 109). Нэг талбайд байх энэ ялгаа нь дүрслэлийн хувийн онцлог гэхээсээ илүүтэй гэрийн амьтдын үүлдэр, угшлын ялгааг харуулж байна гэж үзүүштэй. Хүрлийн хожуу үе болоход евразийн ард түмнүүд хэдийнээ олон үүлдрийн малыг гаргаж аваад байсан юм.

Тээгийн хадны зурагт нохдыг богино багавтар биетэй, соотон чихтэй, цагариган сүүлтэй зурахын зэрэгцээ (Зураг II-14), урт чацтай, нарийн гэдэстэй, үзүүр нь ялимгүй муруй урт сүүлтэй, хол харайн давхиж байгаа (Зураг II-85, 107, 109) гэх мэтээр нэг төрлийн амьтныг ялгаатай дүрсэлсэн нь санаандгүй тохиолдол биш бололтой. Бие галбирын хувьд дээрх ноходтой адил ноход өнөөдрийг хүртэл анх үүсэн гарсан тэр л газартаа байсаар байгаа юм. Нохдын үүлдэр угсааг ДНХ-ийн түвшинд судалсан судалгаанаас үзэхэд хамгийн эртний нохдын дотор Аляскийн маламут, Сибирийн хаскитай Тээгийн хадны зурагт дүрсэлсэн сүүлээ цагаригласан, багавтар биетэй нохой хэв шинжээрээ адилхан байгаа бол Ойрхи Дорнодын салюк хэмээх эртний тайга нохойтой Тээгийн урт чацтай нохой төстэй байна. Үүнээс үзвэл хүрлийн хожуу үед Төв Азид нохдын бие даасан хэд хэдэн үүлдэр бий болсон байна.

Хүрлийн хожуу үеийн хадны зургийн урлагт адууг урт нарийн хүзүүтэй, урт хөлтэй ба бүдүүн бахим хүзүүтэй, богино хөлтэй гэх мэт хоёр өөр хэлбэртэй дүрсэлсэн байдаг бөгөөд Тээгийн хадны зурагт мөн энэ онцлогийг ажиглаж болно. Судлаачид монгол адууг эртний үүлдэр гэж үздэг бөгөөд жижиг биетэй эдгээр адууг пони гэж нэрлэнэ. Пони анх Дорнод Европт бий болж улмаар шилжилт хөдөлгөөний явцад Төв Ази болон Өмнөд Сибирьт тархсан байна. Тээгийн хадны зургийн гол сэдвийн нэг бол богино, бүдүүн хүзүүтэй, бахим биетэй адуун сүрэг болно. Адуун сүргийн дотор нэгээс хоёр хүн заавал оролцуулан дүрсэлдгээс гадна үлэмж том сэгсгэр босоо дэлтэй адууг хүн хөтөлсөн байгаа зэргээр зурсан нь гэршүүлсэн адуу болохыг харуулах ба шүтлэг бишрэлийн тухай онцгой ойлголт төсөөлөл бий болсон байна. Өөр нэгэн сонирхолтой зураг бол нэг хавтгай дээр 3 хүн, 11 адуу, 5 буга, эвэртэй, эвэргүй 2 янгир зэрэг амьтдын дүрс байх ба зохиомжийн хамгийн дээд талд хоёр морины дунд зогсож байгаа хүн, зохиомжийн дунд хэсэгт морь хөтөлсөн нэг хүн, зүүн дээд талд сул зогсох нэг хүн гэх мэт далд өгүүлэмжтэй сэдэвт зураг

болно (Зураг II-69). Зохиомжийн анхаарал татаж байгаа дүрслэл бол бие биеэ харан зогсох хоёр морь, түүний дунд мөөг хэлбэрийн малгайтай, зогсож байгаа хүн юм. Үүнтэй төстэй боловч хүний оронд шон мэт зүйлд уясан хоёр морины зураг Таласын хөндий, Дорнод Казахстан, Енисей мөрний баруун эргийн хадны зурагт байгаа ба карасукийн цаг үед холбогдох бололтой (Шер, 1993). Харин Тээгийн хүн, морины зурагтай адил зохиомж Енисейн Оглахт уулын геометрийн дүрслэлийн хэв маягаар зурсан хүн ба морины дүрс түүнчлэн, Ойрхи Дорнодоос олдсон сав суулган дээр хоёр морь хөтөлсөн зохиомжтой төстэй байна (Шер, 1993). Эдгээр зохиомжийн хамгийн эртнийх нь НТӨ XII зуун, үлдсэн хэсэг нь НТӨ VII зуунд холбогдох аж. Ази тивийн гүнд уг сэдэв бий болсныг хүрлийн үед индоевропчуудын их нүүдэлтэй хамт эртний домогзүйн дүр, сэдэв нэвтрэн орсныг онцолжээ. Тэрээр хоёр морины дунд байх хүн болон шонг угтаа бол ертөнцийн мод гэж үзсэн байна (Шер, 1993). Гэхдээ, Ойрхи Дорнод болон Монгол Алтай, Өмнөд Сибирийн хоорондох уг зургийн үргэлжлэл байхгүй байна. Харин Төв Азийн монгол, түрэг хэлт ард түмний дунд дээрхтэй төстэй Хөхдэй Мэргэн, хоёр шарга морь, Алтан гадас од гэх мэт домогзүйн дүрийг агуулсан бие даасан домог яриа бас бий.

Адууны хувьсал хөгжилд тухайн үед хаа сайгүй элбэг байсан тахь гэрийн адуутай нийлснээр эх газрын уур амьсгалд илүү дасан зохицсон адуун сүрэг бий болсон гэж үздэг. Тахь, гэрийн адуу хоёрын нэгдүгээр үеийн эрлийз морь толгой, сүүл болон биеийн ерөнхий галбир төрх тэжээвэр өвөгтэйгээ адилхан боловч хүзүү нь богино, бахим, бүдүүн байдгаараа ялгаатай байдаг байна. Өөр нэг хавтгай дээр гол төлөв урт нарийн хүзүүтэй 18 адуу, ер бусын дүртэй 2 хүн, 1 буга, 1 янгир бий. Тээгийн урт нарийн хүзүүтэй морь нь өөр үүлдрийн адуу байсныг харуулж байж болох талтай. Тээгийн ихэнх морьдыг сеймын дүрслэлийн уламжлалаар зурсан нь анхаарал татаж байгаа бөгөөд

хүрлийн хожуу үед адууг дүрслэх гол хэв маяг болсон байна.

Хүрлийн хожуу үед Төв Азийн тал хээрийн малчин овог аймгууд нүүдлийн мал аж ахуйд шилжин орж байсан бололтой бөгөөд аж ахуйд адууны үүрэг улам өсөн нэмэгдэхийн хамт морийг унаж эдлэх болжээ. Хиргисүүр, буган хөшөөний соёлын хүрээнд адуу тахил, тайлгын гол мал болж хиргисүүрийн зүүн талд адууны толгой, дөрвөн шийрийг тусгайлан бэлдсэн чулуун байгууламжид тавих болжээ. Ийм чулуун байгууламж 3, 4-өөс эхлээд зарим том хиргисүүрт хэдэн зуугаас 1700 орчим байдгийг судлаачид тэмдэглэсэн байна (Төрбат нар, 2011).

Янгир, аргаль, буга зэрэг туурайтнууд ангийн чухал ач холбогдолтой амьтад байснаас гадна шүтлэг бишрэлийн объект байсан бололтой. Энэ нь эдгээр амьтдын гол онцлог болох эврийг уран сайхны хэтрүүлэгтэй ер бусын сүрлэг томоор дүрсэлж байснаар илэрч байна гэлтэй. Тээгийн хадны зурагт янгирын эврийг нуруу болон сүүлтэй нь холбон дүрсэлсэн тохиолдол зарим хүрэл эдлэл тухайлбал, карасукийн хэв шинжит гэж нэрлэдэг хүрэл хутга болон матганы бариулын төгсгөлд байх янгирын толгойтой хийц маягаараа адил байна (Зураг II-31, 55). Магадгүй, уран сайхны энэ маяг хадны зурагт анх гарч дараа нь энэ “эскиз” хүрэл хутга, матганы бариулын өвөрмөц хэв маяг болсон болов уу. Ю.С.Худяков янгирын толгойн дүрст бариултай хүрэл хутгыг хиргисүүр, буган хөшөөний соёлтой холбоотой тухай санал дэвшүүлсэн байдаг (1993) бөгөөд А.В.Варенов уг саналыг дэмжиж НТӨ XIII-XI зууны Инь улстай нэг цаг хугацаанд байсныг батлах боломж гарч байна гэж үзсэн (Варенов, 2012). Умард Хятадын нутгаас олдсон янгирын толгойн дүрст бариултай хүрэл хутга, матга НТӨ XII-XI зууны үед холбогдож байна. Ийнхүү судалгааны хэрэглэгдэхүүн Тээгийн хадны зураг хиргисүүртэй нэг үеийн дурсгал болохыг тод харуулж байна.

Тээгийн хадны зурагт бугын зураг багагүй хувийг эзлэх ба дүр дүрслэлийн янз

бүрийн уламжлалаар зурсан байх хэдий ч олон салаа нэг ба хоёр сүрлэг том эвэртэй дүрслэх ажээ. Хиргисүүрийн соёлынхонд анчин, гөрөөчин байх үеэс улбаатай буга тахиж шүтэх домог зүйн өргөн хүрээтэй ойлголт төсөөлөл байсантай холбоотой бололтой. Хадны зурагт зарим нэг этгээд амьтдын зураг байгаагаас буга мэт босоо боловч салаагүй урт эвэртэй, урт сүүлтэй Төв Азид эдүгээ байдаггүй гөрөөсний дүрс байлаа (Зураг II-94). Гэхдээ үүнтэй төстэй орикс хэмээх гөрөөс Өмнөд Арабд байх ба Хятадад үхэр мэт сүүлтэй олон салаа эвэртэй Давидын буга хэмээх бас нэг төрөл байх ажээ.

Амьтдыг ийнхүү уран сайхны хэтрүүлэгтэй дүрслэх нь түүнтэй холбоотой онцгой шүтлэг, домог, янз бүрийн зан үйлийн тогтолцоо бий болсны шууд илрэл гэж үзэж болох юм.

Алтайн амьтны загварт урлагт байдаг муруй биет муурын төрлийн араатан, могой бололтой мурилзсан амьтан болон гонзгой дугуйвтар биетэй шөвгөр богино хоншоортой, урт чихтэй жижиг мэрэгчидтэй төстэй ганц нэг амьтны дүрс бий. Энэ дүрс нь хээлтэй амьтны зураг байж магадгүй бөгөөд нэгэн иймэрхүү дүрсийн бөгсний ард дээрхийн адил урт чихтэй тодорхой хэлбэргүй зүйлийг дүрсэлсэн байлаа (Зураг I-1).

Холбоо тээгийн хадны зурагт дөрвөн өнцгийг нь чагтлан холбосон зарим нь дотроо олон цэгтэй онцгой гурван зураг бий (Зураг I-38, 46, 52). Эртний хүмүүсийн ойлголт төсөөллөөр бол дөрвөлжин дүрс нь манай дэлхий ертөнцийн бэлгэдэл болдог бөгөөд түүний доторх олон цэгүүд өвөг дээдсийг төлөөлж байж магадгүй юм (Батсайхан, 2003). Эдгээр дөрвөлжин дүрс хиргисүүрийн оршуулгын газар буюу оршуулгын үеэр болдог зан үйлтэй холбоотой байж болно. Төв Монгол, Өвөр Байгалд улаан зосоор зурсан хүн, шувуу, хос зураас болон олон цэгтэй дөрвөлжин дүрстэй зураг тархсан байдаг ба Сэлэнгийн зосон зургууд гэж томъёолдог.

Төв Азийн эртний ард түмний домог зүйд холбогдох нэг зураг бол гараа ташаандаа

авсан нохой толгойтой, ташааны хоёр талдаа сүүл мэт унжлагатай, хүний биетэй өвөрмөц дүр болно (Зураг II-99). Монгол, түрэг хэлт ард түмэн, тухайлбал, уйгурын гарал үүсэл, Ашина овгийн гарал үүсэл болон нирунчуудын үүслийн тухай домогзүйд чоно, нохой томоохон байр суурь эзэлнэ. Пельогийн цуглуулгын “Ганьжоу-Уйгурын түүх, газарзүйн илтгэлийн умардын хаадын тэмдэглэлийн төвд орчуулга”-ын мэдээгээр “... анх Улаан нохой, Хар нохой тэнгэрээс бууж ирсэн бөгөөд тэдний нэг нь гичий чонотой гэрлэсэн боловч үр удам гараагүй. Дараа нь нэгэн түрэг хот айлаас охин хулгайлан түүн дээр очих болсноор эр хүйстэн төрөхдөө нохой болж, эм хүйстэн нь охид болдог байжээ. Улаан нохойн удмыг “Кызыл-кушу”, Хар нохойн удмыг “Кара-кушу” гэж нэрлэх болсон ба эдгээр ноход ба тэдний эхнэрүүд хоорондоо **түрэг хэл болон дохио зангаагаар** ойлголцдог” гэх сонирхолтой мэдээ байна. Уг домгийн эхэнд умардын зэлүүд газрын Иама хаан, тэр газарт цэрэг дагуулан ирэхэд хоёр цэрэг төөрч будилан явж байгаад тэмээн жим олж дагаж явсаар нэгэн их устай газарт ирэхэд тэмээн сүргийн дэргэд нэг залуу бүсгүйтэй тааралдаж түүнтэй түрэг хэлээр дохио зангаагаар ярьсан гэжээ (Зуев, 2004). Домогт зарим монгол хэлт овог аймгууд түрэг хэлээр ярьж эхэлсэн эсвэл түрэг хэл багагүй гадарладгийг зааж буйгаас гадна уйгурууд нэгэн харь сурвалжит овогтой хоёр ч удаа ураг барилдсан, давхар байгууламжаар холбоотой байсан эртний улбааг хэлсэн бололтой бөгөөд нөгөө илүү тодорхой хувилбар нь чонотой гэрлэсэн Хүннүгийн шаньюйн гүнжийн домог байж магадгүй юм. Зуевын нягталснаар кимакууд Эргүнэ мөрний дунд этгээдэд сууж байжээ.

Хятад сурвалжид олон хувилбараар өгүүлсэн нэгэн домогт хоёр уйгур хүн өлсөж цангаад нэг айлд ороод гарахад айлын эхнэр тэдгээр хүмүүс чоно толгойтой байсныг харж овог аймгийнхандаа хэлж хойноос нь даган явсаар Юйдугюнь буюу Этүгэн ууланд хүрч нөгөө хоёр хүнтэй таарахад тэд “Бид бол бурхад, сеяньто мөхнө” гэж хэлсний дараахан

сеяньто аймаг Хангайн ууланд уйгурт цохигдон мөхжээ (Кляшторный и др. 2009).

Уйгур аймгийн нохой толгойт бурхад Египетийн нөгөө ертөнцийн бурхан Анубистай төстэй байгаа хэдий ч хооронд нь холбон үзэх ямар нэг сэжим харагдахгүй байна.

Тээгийн хадны зураг дахь нохой толгойт хүний дүр монгол, түрэг овог аймгуудын дунд өргөн дэлгэрсэн нохойн эртний домог, чоно нохойтой холбоотой олон домогзүйн үүсэл хөгжлийн он цагийг урагшлуулан үзэх боломжийг олгож байна.

Тэрэгний зураг Минусын хотгорын карасукийн үеийн хадны зурагт чухал байр суурь эзэлдэг бол Монголын говийн бүсэд төдийлөн элбэг тохиолдохгүй байна. Тэрэгний зураг Тахилга уулын нэгэн дөрвөлжин булшны баруун талын хашлага чулуун дээр байгаа ба зургийн зарим хэсэг шороонд дарагдсанаас үзвэл дахин ашигласан байна. Монголын дээр дурдсан бүс нутагт тэрэгний зураг ийнхүү цөөн байгаа нь тэрэг хэрэглэж байгаагүй гэсэн хэрэг биш бөгөөд өөр шалтгаантай гэж үзэж байна. Учир нь Монгол бол хиргисүүр, буган хөшөөний бие даасан хөгжингүй, тэргүүлэх соёлын төв байсан бөгөөд соёлд гарсан хувьсал өөрчлөлтэй холбон үзэх хэрэгтэй байх. Хадны зураг дахь тэрэгний дүр дүрслэлийн үзэл санаа хүрлийн хожуу үеэс эхлээд өөр угсаатны хүрээнд өвөрмөц сүрлэг байдлаар, өөр хэлбэрээр илрэх болсон бөгөөд тэр нь буган хөшөө байсан юм. Буган хөшөөнд морины жолоо өлгөж биеийн хөдөлгөөнөөр залах зориулалтай нум мэт эдлэлийн дүрс буган чулуун хөшөөг хэнд зориулан бүтээснийг тод харуулдаг гол элемент мөн. Буган хөшөө нь хиргисүүрийн соёлыг тээгчдийн хөгжингүй үзэл санааны илрэл морин тэрэгт дайчдын дүр бөгөөд байлдааны тэрэг, морь болон дайчин эрийн бэлгэдлийн нэгдэл юм.

Тээгийн хадны зурагт хүний дүрс цөөнгүй байгаа ба олон тохиолдолд толгойн орой болон хоёр чихний ард багцлан боосон эсвэл өд сөд зүүсэн мэт дүрсэлсэн байхаас

гадна сүрэг адууны дунд хоёр гартаа далавч мэт нэвсгэр өмсгөлтэй, толгойдoo бортого мэт малгай өмссөн хүн, баруун гар талд оройд нь өд сөд зүүсэн бололтой өндөр гозгор малгайтай, цээжиндээ нэвсгэр өмсгөлтэй, гарын хурууг нь сарвайлган дүрсэлсэн өөр нэг хүний зураг бий (*Зураг II-69*). Мөн II-50-р зурагт хоёр гартаа ямар нэгэн зүйлийг барьсан юүдэн маягийн малгайтай, дээл мэт өмсгөлтэй хүний зураг байна. Эдгээр зургууд онцгой өмсгөл зүүсгэлээрээ хүний бусад зургаас эрс ялгарч байгаа нь тухайн овог аймгийн дотор нийгмийн социаль ялгаа гарч онцгой ажил үүрэг хүлээсэн хувь хүн бий болсны илрэл юм. Дээр дурдсан онцгой өмсгөл бүхий хүний дүрслэлүүд Монгол, Сибирийн бөө, удган нарын ханцуйдаа цацагтай өмсгөл зүүсгэл, жигүүртний өд,сөд хатгасан малгайтай төстэй харагдах ажээ. Түүнчлэн, нумаар харваж буй нэгэн дайчны нумын гичрийн үзүүрийг ямар нэг амьтны [могой З.Б] толгой хэлбэртэй дүрсэлснээс үзвэл нумыг ер бусын шидэт зэвсэг гэж үзэж байсантай холбоотой биз ээ (*Зураг II-78*).

Нум, сумаар харвалцан тулалдаж буй эрчүүдийн тэмцэл тулаан нь дотоод болон хөрш овог аймгуудын хооронд билчээр, газар нутгийн төлөөх зөрчил хурцдаж зэвсэгт тэмцлийн арга замаар шийдэж байсныг харуулж байгаа бололтой (*Зураг II-110*).

Тээгийн хадны зурагт морьтон эр (*Зураг II-38, 57*), ан гөрөө (*Зураг I-54, II-37, 57, 78, 85, 90, 97*), сүрэг туурайтан амьтад (*Зураг II-54, 61, 69, 72, 77, 98, 104, 115*) гэх мэт энгийн өгүүлэмжтэй зургаас гадна адуун сүрэг ба хүн, буга, морь, янгир, хүн болон үл танигдах дүрс, хүн ба амьтныг холбож зурсан гэх мэт (*Зураг I-35, 45, II-49, 97, 98*) нарийн далд өгүүлэмжтэй хэдэн зураг байгаа бөгөөд ийм зургууд өөр газарт нэгэн адил байна. Гол бэрхшээл нь зургийн дотор буй үл тайлагдах нийлмэл дүрс, холбоосын утга учрыг тодорхойлох боломжгүйд оршиж байгаа бололтой. Харин бөөгийн хэнгэрэгт хүн, амьтдыг яг хадны зурагт дүрсэлсэнтэй адил маяг загвараар зурсан байх ба дээд, доод тивээр зорчих бөөгийн аяллын тухай нарийн

төвөгтэй ойлголт төсөөлөл дээрх зургуудын утга санааг тайлбарлах нэг түлхүүр байж болох юм. Нөгөө талаас хадны зургийн утга санааг хэзээ ч бүрэн төгс мэдэх боломжгүй гэдэг дээр судлаачид санал нэг байдаг билээ. Иймээс эдгээр зургийг өнөөдрийн судалгааны түвшинд хангалттай харьцуулан тайлбарлах хэрэглэгдхүүн, арга зүй байхгүй байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд шинээр орж буй Тээгийн хадны зурагт варчины дүрслэл болон сеймын дүрслэлийн уламжлал илэрч байгаа боловч орон нутгийн соёлын нөлөөгөөр сэдэв, дүр дүрслэл, хэв маягийн хувьд хувьсан өөрчлөгдсөн байдал ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ хүн, амьтны дүрслэл хэв маягийн мэдэгдэхүйц ялгаатай байгаад үндэслэн тээгийн дүр дүрслэлийн арга гэж үзэж болно.

Тээгийн хадны зургууд ялангуяа, Тахилга уулын зургууд Өмнөд Сибирийн он цагийн үечлэлээр хожуу хүрлийн эхнээс эхлээд төмрийн түрүү үе хүртэлх цаг хугацааг хамарч байна. Тээгийн хадны зургийн ихэнх хэсэг, хиргисүүр, буган хөшөөний соёл хоёр, нэг цаг үеийн дурсгал болохыг харьцуулсан судалгаа харуулж байна.

Хэрэглэгдхүүнээс үзвэл Тээгийн хадны зургийг хиргисүүрийн соёлыг тээгчид бүтээсэн гэх үндэстэй байна. Тахилга уулын II-58-р зурагт дүрсэлсэн янгир бололтой

амьтан он цагийн хувьд энеолит ба хүрлийн түрүү үед, II-35-р зурагт дүрсэлсэн янгир түрэгийн үед холбогдох бололтой.

Угсаатны зүйн харьцуулсан судалгаанаас үзвэл хожмын монгол, түрэг хэлт ард түмний домогзүйн сэдэв болон дүр ямар нэг хэмжээгээр Тээгийн зурагт ажиглагдаж байна. Үүний хамт Тээгийн зарим зургийн дүрслэл ба зохиомж, утга агуулгатай төстэй байж болох зураг дүрс Ойрхи Дорнод, Египетэд байна. Гэхдээ энэ тохиолдол нь соёлын нөлөө гэхээсээ илүүтэй өөр өөр газарт ойролцоо цаг хугацаанд ижил төстэй зүйл гарч болохыг харуулж байна гэж үзлээ.

Хиргисүүрийн талбайд орших хадны зургийг сонгон судалсан анхны туршиц ажлаар хиргисүүрийн соёлыг тээгчдийн нийгэм, соёл, аж ахуйд гарсан өөрчлөлт, шүтлэг бишрэлийн тухай ойлголт төсөөлөл зэрэг олон талт чухал асуудлыг судлах сурвалж болгон ашиглах боломж байгаа нь харагдав. Гэхдээ судалгааны арга зүйг цаашид улам боловсронгуй болгож хиргисүүр, хадны зургийг цогцоор нь судлахад анхаарах хэрэгтэй байна.

Монголын хүрлийн хожуу үеийн овог аймгуудын дунд тодорхой гарал үүсэл бүхий нийгмийн бүлэг давхраа хэдийнээ бий болохын хамт бөөгийн үзэл санаатай төстэй үзэл суртал төлөвшин тогтсон байжээ.

НОМ ЗҮЙ

- Батсайхан З., 2003. Сэлэнгийн хэмээх зосон зургуудыг шинээр тайлбарлах нь. МУИС-ийн ЭШБ. *Археологи-Антропологи, Угсаатан судлал*. УБ. х. 34-39
- Варенов А.В., 2012. Южносибирские культуры эпохи ранней и поздней бронзы в Восточном Туркестане. с. 12
- Зувев Ю.А., 2004. Самое сильное племя. Историко-Культурные Взаимосвязи Ирана и Дешт- и Кипчака в 13-18 вв. *Материалы международного круглого стола Алматы 2004*. с. 42-43
- Кляшторный и др. 2009
- Кляшторный С.Г., Султанов Т.И., 1993. *Государства и народы Евразийских степей: от древних к Новому времени*. СПб.
- Ковалева О.В., 2008. *Петроглифы эпохи поздней бронзы хакасско-минусинской котловины*. Новосибирск.

- Ковтун И.В. 2001. Изобразительные традиции эпохи бронзы Центральной и Северо-Западной Азии. *Проблемы генезиса и хронологии иконографических комплексов Северо-Западного Саяно-Алтая*. Новосибирск, с. 71
- Кубарев В.Д., 2007. Палеоэкономика населения Монгольского Алтая (по петроглифам и этнографическим источникам). *Алтай-Саянская горная страна и соседние территории в древности*. Новосибирск, с. 275-285
- Леонтьев Н.В., 1980. Колесный транспорт эпохи бронзы на Енисее. *Вопросы археологии Хакасии*. Абакан, с. 78-81
- Миклашевич Е.А., 1995. Петроглифы эпохи поздней бронзы (Южная Сибирь и Средняя Азия). *Наскальное искусство Азии*. Кемерово. Вып. 1. с. 34
- Новгородова Э.А., 1984. *Мир петроглифов Монголии*. М. Рис. 50
- Новожинов В.А., 1993. Петроглифы долины реки Байконур. *Современные проблемы изучения петроглифов*. Кемерово, с. 155
- Новожинов В.А., 2002. *Петроглифы Сары-Арки*. Алматы. Рис. 8, табл. 2, 6, 8
- Пяткин Б.Н., 1977. *Некоторые вопросы датировки петроглифов Южной Сибири*. Кемерово. с. 62-71
- Пяткин Б.Н., Миклашевич Е.А., 1987. О культурной принадлежности петроглифов эпохи бронзы. *Проблемы археологии степной Евразии*. Тез. докл. конф. Кемерово, Ч-1. с. 129-130
- Савинов Д.Г., 1993. *Население среднего Енисея в эпоху сложения скотоводческих обществ (III тыс. до н.э. - середина I тыс. н.э.)*. с. 61-72
- Савинов Д.Г., 2007. 98-103
- Самашев З.С., 1992. *Наскальные изображения Верхнего Прииртышья*. Алма-Ата. рис. 26, 52, 167, 168; с. 152-154
- Төрбат Ц., Баярсайхан Ж., Батсүх Д., Баярхүү Н., 2011. *Жаргалантын амны буган хөшөөд*. УБ. 192 х.
- Худяков Ю.С., 1993. Вооружение кочевников Южной Сибири и Центральной Азии в эпоху бронзы. *Военное дело населения юга Сибири и Дальнего Востока*. Новосибирск, с. 69-70
- Шер Я.А., 1993. "Господин коней" на берегу Енисея. *ПАВ №6*. с. 17-22; таб. 1

РЕЗЮМЕ

РЕЗУЛЬТАТЫ АРХЕОЛОГИЧЕСКИХ ИССЛЕДОВАНИЙ ПЕТРОГЛИФОВ И ХЕРЕКСУРОВ НА ТЕРРИТОРИИ БАЯНХОНГОРСКОГО АЙМАКА МОНГОЛИИ

З.БАТСАЙХАН, У.ЭРДЭНЭБАТ, Б.ОЮУНТУЯА, Ч.АМАРБИЛИГ

При проведении археологических исследований более чем 700 наскальных изображений из местности Тээг Баянхонгорского аймака четко прослеживаются следы влияния варчинской изобразительной традиции и сейминско-турбинского транскультурного феномена, однако, заметны и следы воздействия местных культурных традиций, в результате которых произошли некоторые эволюционные изменения в тематике, образах и в типологии петроглифов. На основании заметных типологических отличий, присутствующих в методах изображения людей и животных, можно выделить и местную, Тээгинскую изобразительную традицию.

Согласно Южно-Сибирской хронологической классификации, петроглифы местности Тээг, в особенности наскальные изображения горы Тахилга уул относятся к временному


промежутку от начального периода поздней бронзы до начала железного века. Из результатов сравнительных исследований видно, что большинство петроглифов местности Тээг являются одновременными памятниками с херексурами и оленными камнями.

По материалам исследований можно вполне обоснованно предположить, что наскальные рисунки местности Тээг созданы носителями культуры херексуров. Изображение №58 горы Тахилга уул, где выбита фигура животного, напоминающего горного козла, может относиться к энеолиту – началу бронзы, рисунок №35, где изображен горный козел, скорее всего датируется тюркским временем.

Из результатов этнографических сравнительных исследований можно заметить, что в петроглифах местности Тээг в какой-то степени заметны мифологическая тематика и художественные образы более поздних народов монгольской и тюркской языковых групп. Кроме того, на Ближнем Востоке и в Египте присутствуют рисунки, тематически, композиционно и образно схожие с петроглифами из местности Тээг Баянхонгорского аймака. Но, по нашему предположению, это не является следствием взаимного влияния культур, это, скорее всего, является доказательством того факта, что в одно и то же время в различных регионах мира могут происходить вполне схожие между собой процессы.

Первые опыты исследования петроглифов, расположенных на площади распространения херексуров, показали, что их можно использовать в качестве археологических первоисточников информации для изучения многих важных вопросов жизни носителей культуры херексуров, таких как перемены в их культуре, хозяйстве, вероисповедании и мировоззрении. Но, методы исследований требуют дальнейшего совершенствования, необходим комплексный подход в изучении херексуров и наскальных изображений.

Таблиц 1.



Таблиц 2.

Хурлийн хошуу үе	Зураасан дүрслэл			Сүүдэр дүрслэл			Геометрын дүрслэлийн арга		
	НТӨ XIII-X зуун								
	НТӨ X-IX зуун								
	НТӨ VIII-VI зуун								
	Төмрийн түрүү үе								

Хадны сүг зураг



Зураг I-1



Зураг I-11



Зураг I-18



Зураг I-20



Зураг I-27



Зураг I-35



Зураг I-38



Зураг I-45



Зураг I-46



Зураг I-52



Зураг I-54



Зураг II-14



Зураг II-19



Зураг II-37



Зураг II-38



Зураг II-49



Зураг II-54



Зураг II-55



Зураг II-57



Зураг II-69



Зураг II-72



Зураг II-77



Зураг II-78




Зураг II-82



Зураг II-85



Зураг II-93



Зураг II-98



Зураг II-99



Зураг II-104



Зураг II-109



Зураг II-110



Зураг II-113



Зураг II-50



Зураг II-115



Зураг II-31



Зураг II-42



Зураг II-53



Зураг II-61



Зураг II-90



Зураг II-94



Зураг II-97



Зураг II-107